



Хууль Зүйн Яам

Эрх Зүйн Мэдэгдэл

ТҮР ХОРИОНД ОРСОН ЭТГЭЭДЭД ГАРДУУЛАХ НИЙТЛЭГ ЭРХ ЗҮЙ (ЭРҮҮГИЙН БАЙЦААН ШИЙТГЭХ ХУУЛИЙН 63 БА 63-1 ЗҮЙЛ)

**Доорх мэдээллүүдийг таны ойлгох хэл дээр бичиж танд өгсөн байх шаардлагатай.
Та энэ баримт бичгийг хоригдох хугацаандаа хадгалах эрхтэй.**

Таныг шоронд хоригдох ял шийтгэл авах ямарваа нэгэн гэмт хэрэг буюу зөрчил үйлдсэн эсвэл үйлдэхийг завдсан болоход сэжиглэсэн нэг эсвэл хэд хэдэн шалтгаан байгаа учраас таныг түр хорионд оруулж саатуулах тухай танд мэдээлсэн болно.

Та өөрийн түр хоригдох болсон зөрчлийн утга шинж, огноо ба байрлалыг мэдэх бүрэн эрхтэй болон өөрийг тань түр хорих болсон тодорхой шалтгаануудыг мэдэх эрхтэй. 24 цагийн хугацаатай үргэлжилж болох түр хорионы үеэр таны үйлдсэн хэргийн дагуу таныг байцаах болно.

Түр хорионы хугацаа дуусахад хэрвээ таны үйлдсэн хэргийн ял шийтгэлийн дагуу танд дор хаяж нэг жилийн хорих ял оноосон тохиолдолд Улсын прокурор эсвэл шүүгч нар таны түр хорих хугацааг цаашид дахин 24 цагаар үргэлжлүүлэн сунгах эсэхийг шийдвэрлэх эрхтэй. Энэ шүүхийн байгууллага нь таныг шүүхэд хүрэлцэн ирэх зөвшөөрлийг олгох эрхтэй.

Түр хорих хугацааг дуусахад Улсын прокурорын эсвэл шүүгчийн шийдвэрийн дагуу таны хэргийг захиргааны шүүхэд хэрэг үүсгэн шийдвэрлүүлэх боломжтой эсвэл таныг суллан чөлөөлж болно. Эхний тохиолдолд та түр хорих хугацааны эцсээс тооцоолж 20 цагийн хугацаанд шүүгчээр хэргээ шийдүүлэх үүргийг хүлээнэ.

Үүнээс гадна та дор дурдсан эрхтэй:

Зарим хүмүүст мэдээлэл хүргэх

Та түр хорионд орсон байдлаа харгалзаж хамтран амьдрагчдаа, эсвэл эцэг эхийнхээ хэн нэгэнд, эсвэл өөрийн ах эсвэл эгч рүү шууд утсаар ярьж үүний тухай мэдээллийг хүргэх, тэдэнд түр хорионд орсныхоо тухай мэдэгдэж болно.

Та мөн ажил олгогчдоо энэ мэдээллийг хүргэж болно.

Хэрвээ та гадаад улсын иргэн бол та өөрийн улсын консулын газарт үүний тухай мэдээлж болно.

Даван гарах боломжгүй тохиолдлуудаас бусад тохиолдлуудад шүүгчид өргөдөл гаргасан хугацаанаас 3 цагаас хэтрэхгүй хугацаанд та уг хэрэгт оролцоно.

Хэрвээ та хууль зүйн аливаа нэгэн хамгаалалттай бол таны асран хамгаалагч, таны куратор эсвэл таны төлөөлөгч нарт таны түр хоригдсоны тухай мэдээллэх болно.

Улсын прокурор эсвэл анхан шатны шүүгч нь нотолгоо цуглуулахад зайлшгүй шаардлагатай эсвэл хэн нэгний амь насанд, эрх чөлөөнд эсвэл хэн нэгний бие махбодид халдахаас сэргийлэх зорилгоор хэрвээ шаардлагатай гэж үзсэн бол үүнийг хойшлуулах эсвэл мэдээг хүргэх боломжгүй гэж шийдэх эрхтэй.

Хэн нэгэнтэй холбоо барих

Та өөрийнхөө түр хорионд орсон тухай мэдэгдэх шаардлагатай хэн нэгэнтэй бичгээр, утсаар эсвэл ярилцлага хийж холбогдон харилцах хүсэлт гаргаж болно.

Шүүхийн цагдаагийн хэлтэсийн ажилтан нь хэрвээ уг хүсэлт таныг хоригдох болсон хэргийн шалтгаануудтай тохирохгүй байх, эсвэл үүнээс үүдэж аливаа нэгэн зөрчил үүсэх эрсдэл байгаа гэж үзвэл тэр таны хүсэлтийг хүлээн авахгүй байж болно. Тэр энэ уулзалтын үргэлжлэх хугацааг түүний эсвэл өөр нэгэн албан хаагчийн хяналтан дор 30 минут үргэлжлэхээр тогтоох ба уулзалтын нөхцөл байдал, огноо цаг өдөр зэргийг мөн адил тодорхойлно.

Эмчийн үзлэгт хамрах

Та эмчийн үзлэгт хамрах хүсэлт гаргаж болно. Хоригдох хугацааг уртсгасан тохиолдолд та дахин давтан эмчийн үзлэгт хамрах хүсэлтийг мөн адил гаргаж болно.

Хэрвээ та хууль зүйн хамгаалалттай нэгэн бол таны асран хамгаалагч, таны куратор эсвэл таны тусгай төлөөлөгч нар таныг эмчийн үзлэгт хамруулахыг хүсэх эрхтэй.

Мэдэгдэл хийх, асуултанд хариулах эсвэл хариу өгөхгүй байх

Та биеийн байцаалтаас татгалзсан бол шүүх хурлуудын үед :

- мэдэгдэл гаргах эрхтэй,
- таниас асуусан асуултад хариулах,
- эсвэл хариу өгөхгүй байх эрхтэй.

Өмгөөлөгчийн туслалцаа авах

Өмгөөлөгчийн сонголт

Түр хорих ажиллагаа эхлэснээс эхлэн шүүх хурлын аливаа нэгэн мөч хүртэл түр хорих хугацааг сунгасан тохиолдолд энэ сунгалтын эхэнд та өөрийн сонголтоор өмгөөлөгчийн туслалцаа нэхэх эрхтэй. Хэрвээ өмгөөлөгч сонгож авах боломжгүй эсвэл өмгөөлөгчтэй холбоо барих боломжгүй бол та бичиг хэргийн газраас томилсон өмгөөлөгчийн туслалцаа авахыг хүсэж болно.

Таныг өмгөөлөх өмгөөлөгчийг таны холбоо барьсан этгээдийн хэн нэг нь мөн адил томилж болно: энэ тохиолдолд та өмгөөлөгч томилсон болохыг өөрөө баталгаажуулах шаардлагатай.

Хэрвээ та хууль зүйн хамгаалалттай нэгэн бол таны асран хамгаалагч, таны куратор эсвэл таны тусгай төлөөлөгч нар таны өмгөөлөгчийг томилох эсвэл зохих төлөөллөөс томилох хүсэлт гаргаж болдог.

Өмгөөлөгчийн туслалцаа ба оролцох хугацаа

Өмгөөлөгч нь ярилцлагын нууцыг хадгалсан нөхцөл байдалд тантай 30 минутын хугацаанд ярилцах эрхтэй; хорих хугацааг сунгасан тохиолдолд та өөрийнхөө өмгөөлөгчтэй дахин уулзах хүсэлт дахин гаргаж болно.

Үүний зэрэгцээ хэрвээ та хүсэлт гаргавал тэр таны маргаантай байдлууд, шүүх хуралд оролцох, таны үйлдсэн үйлдлүүдийг давтах, үйлдлүүдийг тодорхойлох хэрэгт оролцож болно.

Энэ тохиолдолд таны анхны шүүх хурал нь таны биеийн байцаалт дээр зөвхөн тулгуурлаж байгаа тохиолдлоос бусад тохиолдолд өмгөөлөгчид хүсэлт гаргаснаас 2 цагийн хугацаа өнгөрөөгүй байхад таны өмгөөлөгчгүйгээр

эхлэхгүй. Гэсэн хэдий ч таны анхны шүүх хурал таны өмгөөлөгчийн эзгүйд ч гэсэн Улсын прокурорын эсвэл анхан шатны шүүгчийн зөвшөөрлөөр хэрвээ байцаалт нь үүнийг шаардаж байвал тэр дороо эхэлж болно.

Хэрвээ таны өмгөөлөгч шүүх хуралд оролцож байхад ямарваа нэгэн маргаан үүсвэл шүүх хурал нь таны хүсэлтээр таныг өмгөөлөхтэй ярилцах зорилгоор түр завсарлаж болно.

Улсын прокурор, анхан шатны шүүгч эсвэл хорих эрх чөлөөний шүүгч нь гэнэтийн шалтгаанаар маш онцгой гойд тохиолдолд хэрвээ та таван жилийн шоронгийн ял эдлэх шийтгэл хүлээж байвал, дээд хэмжээгээр 12 цагийн түрш нэг удаа шинэчлэх эрхтэйгээр таны өмгөөлөгчийн таны шүүх хуралд оролцох туслалцааг хойшлуулан түдгэлзүүлж болно.

Хэлмэрчийн туслалцаа авах

Хэрвээ та франц хэлээр ярьдаггүй ба ойлгодоггүй бол та үнэ төлбөргүй шүүх хурлуудынхаа үеэр болон өмгөөлөгчтэйгээ харилцах зорилгоор хэлмэрчийн туслалцаа авах эрхтэй.

Түр хорионы эцэст өөрийн ажиглалтуудыг танилцуулах

Та Улсын прокурорт эсвэл анхан шатны шүүгчид шүүгч таны түр хорионы хугацааг сунгах шийдвэр гаргаж байхад, та өөрийн санал бодол ба ажиглалтыг танилцуулж болно.

Хэргийнхээ зарим хэсгүүдтэй танилцах

Таны гаргасан хүсэлтээр эсвэл таны өмгөөлөгчийн хүсэлтээр та түр хориог сунгахын өмнө доорх байдлуудтай танилцах эрхтэй:

- таныг түр хорионд оруулсан тухай протоколын мэдэгдэл;
- таныг үзсэн эмчийн гаргасан эрүүл мэндийн гэрчилгээ эсвэл гэрчилгээнүүдтэй танилцах;
- шүүх хурлуудын протоколуудтай танилцах.

Улсын прокурорт танилцуулах

Түр хорионы эцэст та нэг жилийн хугацаанд багтаж Улсын прокурорт баталгаатай захидлаар эсвэл нотариатын нотолгоотой итгэмжлэлээр өөрийн танилцуулгыг боловсруулах зорилгоор хэргийнхээ баримтуудтай танилцах тухай мэдэгдэл гаргаж болно.